



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/154

Хэрлэн сум

Арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 09 дугаартай тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор "Архидалтгүй Хэнтий" дэд хөтөлбөрийн хүрээнд иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчих хэрэг, зөрчлийг таслан зогсоох, бууруулахад төр, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг таслан зогсоё" нэгдсэн арга хэмжээг 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсугай.

2. "Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох зөрчлийг таслан зогсоё" нэгдсэн арга хэмжээний хүрээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх үүрэг бүхий олон нийтийн эргүүлд ажиллах байгууллага, аж ахуй нэгжийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Олон нийтийн эргүүлээр ажиллах байгууллага, аж ахуй нэгжийн албан хаагчдыг нэгдсэн зохион байгуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон замын хөдөлгөөний аюулгүй байдлын журам зөрчсөнөөс үүсэх хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлыг иргэд, олон нийтэд үр дүнтэйгээр зохион

байгуулан ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /Цагдаагийн хурандаа О.Ганбат/-т үүрэг болгосугай.

4. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд төрийн албан хаагчдын манлайллыг нэмэгдүүлэх чиглэлээр байгууллагын дотоод журам, төрийн алба хаагчийн үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээнд төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг зөрчин, архидан согтуурч зөрчил гаргасан алба хаагч нарт хүлээлгэх хариуцлагыг тодорхой тусган хэрэгжүүлж ажиллахыг нийт төр захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д тус тус даалгасугай.

5. Олон нийтийн эргүүлд ажиллах, аж ахуйн нэгж байгууллага нь эргүүлд зарцуулагдах шатахуун, авто машиныг хариуцаж зохион байгуулах бөгөөд архи, согтууруулах ундааны зүйлийн талаарх хор уршиг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийг аймгийн Цагдаагийн газартай хамтран сурталчлах ажлыг зохион байгуулсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ
 УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ОЛОН НИЙТИЙН ЭРГҮҮЛД АЖИЛЛАХ
 БАЙГУУЛЛАГА АЖ АХУЙ НЭГЖҮҮДИЙН ХУВААРЬ

Д/д	Байгууллага, аж ахуй нэгжийн нэр	Цаг хугацаа	Эргүүлд ажиллах хүний тоо	Тайлбар
1	Авто тээврийн төв	2017 оны 4 сарын 27-ноос 5 сарын 02 17:00-00:30	1 байгууллагаас 3-5 албан хаагч, ажилтан, ажиллах	
	Харгуй ТӨХК			
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба	2017 оны 5 сарын 03-09 хүртэл 17:00-00:30	1 байгууллагаас 3-5 албан хаагч ажилтан, ажиллах	
	Аймгийн Засаг даргын Тамгын газар			
3	Онцгой байдлын газар	2017 оны 5 сарын 10-16 хүртэл 17:00-00:30	1 байгууллагаас 3-5 албан хаагч ажилтан, ажиллах	
	Чацаргана авто сургууль			
4	Аймгийн ИТХ	2017 оны 5 сарын 17-23 хүртэл 17:00-00:30	1 байгууллагаас 3-5 албан хаагч ажилтан, ажиллах	
	БХТН-ийн авто сургууль			
5	Шүүхийн шинжилгээний алба	2017 оны 5 сарын 24-30 хүртэл 17:00-00:30	1 байгууллагаас 3-5 албан хаагч ажилтан, ажиллах	
	Байгаль орчин, аялал жуулчлалын газар			
6	Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар	2017 оны 5 сарын 31-ээс 6 сарын 06-ны хүртэл 17:00-00:30	1 байгууллагаас 3-5 албан хаагч ажилтан, ажиллах	
	Хан Хэнтий чуулга			